



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А150

Дэлгэрмөрөн

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр  
хийгдсэн ажлуудыг хүлээлцэх ажлын  
хэсгийг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.2 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хийгдсэн “Цахим худаг” ажлын явцад хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ч.Хүчитбаатар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Гишүүдэд Ч.Бямбадорж (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Г.Золбоо (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

Р.Мөнхбилэг (Тамгын газрын нягтлан бодогч)

О.Баяржаргал (Орон нутаг хариуцсан нягтлан бодогч)

С.Очирбат (Дэлгэрмөрөн 5 дугаар багийн Засаг дарга)

Ц.Ганбаатар (Тамгын газрын нярав)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг нүд үзэн, гэрээ, техникийн тодорхойлолтын дагуу хийгдсэн эсэх дээр дүгнэлт, тэмдэглэл хөтлөн фото зургаар баталгаажуулан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

D /bichig hereg/ Zahiramj -2022 on

642201059